

ТАНИЛЦУУЛГА

Эрүүл мэнд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай” А/69, 48 дугаар хамтарсан тушаалын зарим хавсралтыг шинэчлэн батлах, зарим хавсралтын нэр өөрчлөх тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.11-д “Энэ хуулийн 13.2.4-т заасан ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, заавар, маягт батлах тухай” 2018 оны А/69, 48 дугаар хамтарсан тушаал батлагдан хэрэгжсэн.

Уг тушаал хэрэгжсэнээр асаргааны тэтгэмжийн хамрах хүрээг оновчтой тогтоож, асаргааны тэтгэмжид зарцуулах хөрөнгийг үр ашигтай зарцуулах зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байгаа ч тушаалын зарим хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулан илүү боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Тиймээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/213 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг /ЭМЯ-ны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлүүдийн ерөнхий мэргэжилтнүүд уг ажлын хэсэгт орж ажилласан/ тушаалын хоёрдугаар хавсралт “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт” болон дөрөвдүгээр хавсралт “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох заавар”-ыг шинэчлэн боловсрууллаа.

Одоо хэрэгжиж буй “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-д оношийн 14 бүлэг, нийт 120 орчим төрлийн өвчин багтдаг бол шинэчлэгдсэн тушаалын төсөлд зайлшгүй орвол зохих өвчин, эмгэгүүд нэмэгдэж оношийн нийт 20 бүлэг, 131 орчим төрлийн өвчин, эмгэг багтаж байна.

Мөн одоо хэрэгжиж байгаа тушаалын 3 дугаар хавсралт буюу “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур, үзүүлэлт” нь жагсаалтад орсон бүх өвчнийг нэг л үнэлгээгээр үнэлдэг бөгөөд тэрхүү үнэлгээний асуумж нь зарим өвчний төрөл болоод насны ангилалд тохирохгүй байгаа. Тухайлбал, сонсголын бэрхшээлтэй болон гемофилтэй хүүхдүүд өдөр тутмын үйлдлүүдийг хэний ч тусламжгүй өөрсдөө хийж

бүрэн чаддаг тул үнэлгээн дээрээ тэнцчихдэг. Үнэлгээнд тэнцсэн учир тухайн хүүхдэд асаргаа шаардлагагүй гэхээр эцэг, эхчүүдийн зүгээс өвчний заалт нь байгаа учир орох ёстой гэх мэтээр зөрчилдөх нөхцөл байдал маш ихээр үүсч байгаа юм.

Тиймээс 0-16 насны хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай эсэхийг тодорхойлох, байнгын асаргааны хугацаа сунгах үйл ажиллагааг илүү боловсронгуй, зөрчил маргаангүй болгох үүднээс өвчин гэмтлийн жагсаалтад “Өвчний заалт, Шалгуур үзүүлэлт” гэсэн хэсгийг нэмж, өвчин, эмгэгийн заалт тус бүрийн шалгуур үзүүлэлт, тайлбарыг нэмж оруулсан.

Түүнчлэн уг тушаалыг хэрэгжүүлж ажилладаг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын аймаг, дүүргийн салбар комиссын 0-16 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй холбоотойгоор эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх хугацааг 24 сар, 36 сар гэснийг 12-24, 12-36 сар болгож өөрчилсөн болно.

Энэхүү тушаалд нэмэлт, өөрчлөлт орсноор хууль, журмын хэрэгжилт сайжирч, төрийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагчдад түргэн шуурхай, чанартай хүргэнэ.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ